

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-8

---

**1.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 4-7

**2.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/ 7-8

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
05 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Бейсен, Х.Болорчулуун, Н.Ганибал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Ц.Туваан нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Саранчимэг хариулав.

**Б.Саранчимэг:** “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

*Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Г.Ганболдын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Саранчимэг хариулав.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

**Б.Саранчимэг:** “Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 12 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 24 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 48 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,  
Лхагва гараг

Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим 10 цаг 24 минут.

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Саранчимэг:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 63.2 хувьтай болсон учраас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна.

Тилеуханы Аубакир гишүүн Баян-Өлгий аймаг, 2 дугаар тойрог ирсэн байна. Жигжидийн Батжаргал Төв аймаг чөлөөтэй байна. Буланы Бейсен гадаадад томилолттой. Баян-Өлгий аймаг, 2 дугаар тойрог. Хаянгаагийн Болорчулуун Дорнод, 7 дугаар тойрог томилолттой байна. Гочоогийн Ганболд Өвөрхангай аймаг, 10 дугаар тойрог ирсэн байна. Наянтайн Ганибал Сүхбаатар, 12 дугаар тойрог чөлөөтэй байна. Гонгорын Дамдинням Дархан-Уул, 19 дүгээр тойрог ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат Хэнтий, 18 дугаар тойрог ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг Дундговь, Говьсүмбэр, 6 дугаар тойрог ирсэн байна. Нанзадын Наранбаатар Өмнөговь, 11 дүгээр тойрог ирсэн байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор Сэлэнгэ, 13 дугаар тойрог одоо орж ирж байгаа гэж байна. Батсүхийн Саранчимэг Баянзүрх,

22 дугаар тойрог ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн Архангайн 1 дүгээр тойрог ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан Төв аймаг, 14 дүгээр тойрог ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл Увс, 15 дугаар тойрог ирсэн байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг Завхан, 9 дүгээр тойрог ирсэн байна. Төмөртоогоогийн Энхтүвшин Дорноговь, 8 дугаар тойрог ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгт, Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Цаглавар батлах тухай.

Хоёрт, Байнгын хорооны тогтоолын төсөл Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Идэрбат гишүүн байна. Идэрбат гишүүний микрофоныг өгье.

**Ц.Идэрбат:** Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Байнгын хороон дээр нэг асуудал бас хэлэлцэх нь зүйтэй гэж санал оруулах гэж байгаа юм. Юу гэхээр энэ цаг үе ирж, хавар урин цаг ирж байна. Өнгөрсөн өвөл, хавар бол нэлээн хүндэрлээ. Тэгээд энэ үед бас манай улсын хэмжээнд байгаа энэ аймаг дундын отрын бүс нутаг гэсэн 8, 9 төрлийн газар байдаг. Тэрний хамгийн том нь бол манай Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумдыг хамарсан 180 гаруй мянган га газар нутгийг эзэмшдэг. Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бүс нутаг байгаа. Энэ дээр манай чуулганы завсарлагаагаар эдгээр сумдад ажиллах үеэр энэ отрын бүс нутгийн үйл ажиллагаа орон нутагтай ямар ч уялдаа холбоо байхгүй, орон нутгийн тэнд

ажиллаж амьдарч байгаа ард иргэдэд асар их дарамт учруулдаг. Дээрээс нь энэ отрын бүс нутагт яг хэн гэдэг малчин ямар зохицуулалтаар орж ирж байгаа нь тодорхой биш гэх мэтийн. Тэгээд орон нутагт малын өвчин хууч тараадаг олон хүндрэлтэй асуудлууд байна.

Ер нь энэ Хунс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ улсын хэмжээнд байгаа отрын бүс нутгийн энэ үйл ажиллагааны талаарх тодорхой мэдээллүүдийг Байнгын хороон дээр бас авч хэлэлцэх нь би бас зүйтэй болов уу. Өвөл болдгоороо л болно гэсэн ийм санал байна.

**Б.Саранчимэг:** Идэрбат гишүүн маш чухал асуудлыг хөндөж байна. Тэгээд бас энэ таширамд хэлэхэд Бэлчээрийн хууль дээр манай Байнгын хорооноос 5 бүсэд хэлэлцүүлэг хийгдээд энэ тал дээр бас нэлээн улс орныг хамарсан хэлэлцүүлгүүдийг хийж явж байгаа. Тэгээд эндээс харахад өмнө нь бол малчид энэ Бэлчээрийн хуулийг гаргахад бас их нэлээн дургүйцлээ илэрхийлдэг байсан бол одоо ер нь энэ цаг үед энэ бэлчээрийн асуудал, энэ отрын асуудал гээд маш их хүндрэлтэй болчихсон байгаа үед энийг ер нь хууль, эрх зүйгээр зохицуулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд өнөөдөр бас манай Хөдөө аж ахуйн сайд өөрөө бас алга байна. Тэгэхээр энэ тал дээр бас бэлтгэл ажлыг нь хангуулаад, дараагийн Байнгын хороогоор ирэх 7 хоногтоо энэ асуудлыг оруулъя.

Өөр хэлэлцэх асуудалтай холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

**Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Та бүхэнд бас тараагдсан байгаа цаглавар. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 23 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 83 дугаар захирамжийг маань баталсан байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд энэ дар дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороо баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны энэ хаврын чуулганы 5 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа учраас энэ цаглаварыгаа батлахын өмнө бас гишүүдээсээ санал авах учиртай. Тэгээд энэ салбартай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Нэрээ өгье. Цаглавар батлахад гишүүдийн нэрсийг авч байна. Идэрбат гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн саналаа хэлье.

**Г.Ганболд:** 5 сарын цаглавар тээ? Тэгэхээр чинь маргааш нөгөө энэ Үндсэн хуулийн асуудал ороод ирвэл тэгээд 5 сард ч ерөөсөө өөр асуудал огт хэлэлцэхгүй болоод явчих байх тээ? Тэгэхээр заавал ийм хуурамч юм шиг ийм юм батлахын хэрэг байгаа юм уу ер нь? Дэд ажлын хэсгүүд нь болох юм уу? Чи тэрийг яг Үндсэн хууль хэлэлцэхтэй холбогдуулан яг ямар ажлын хэсэг юу хуралдаж болох юм байна, юу болохгүй вэ гэдгийг яг тодорхой хэлээд өгөөч гэж.

Хоёрдугаарт нь хэдүүлээ жаахан ингэмээр л байх юм даргаа. Энэ Их Хурлын энэ Даргын зөвлөл эд нар дээр жаахан дуугарч энэ гол хуулиудаа энэ яг мэргэжлийн Байнгын хороон дээр яахгүй бол бид нар чинь Аялал жуулчлалын хуулиа Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд яваад байдаг. Тэр аялал

жуулчлалын салбар чинь бол бид нарын яг гол мэргэжлийн хүмүүс би байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг энийг Эдийн засгийн байнгын хороон дээр ороод л тэгээд л өчнөөн л олон асуудалтай юмнууд орж ирсэн. Та, бид чуулган дээрээ мэдэж байгаа шүү дээ тийм ээ? Тэгэхээр зэрэг ингээд энийг жаахан ойлгуулаад нөгөө мэргэжлийн Байнгын хороонд биш өөр Байнгын хороогоор орохоор ингээд оруулж ирж байгаа хууль нь ч гэсэн сая бол өчнөөн асуудалтай. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гараад тэгээд 44 ч билүү заалттай хууль дээр чинь бараг 95, 6 санал хураалт явуулаад тэр хэмжээгээрээ ингээд л Их Хурлын юм уу, төрийн байгууллагын үнэлэмж унагаад тэгээд ийм юмнууд дээр жоохон даргаа ач холбогдол өгмөөр байна.

Тэгэхгүй бол хэдүүлээ бас энэ том Байнгын хороогоор нэг муу гэрийн тэжээвэр амьтан тэгээд л ийм жижиг, сажиг юмнууд руу ороод байхаар бас жаахан жижигхэн байна. Асуудлууд нь зарим нь. Тэгээд энэ дээр бас дарга жаахан анхаарч энэ Даргын зөвлөлийн хурал дээр ер нь өөрсдийнхөө салбарын юмыг ер нь өөр рүүгээ авахгүй бол энэ Эдийн засгийн байнгын хороо руу ер нь хамаг юмнууд төвлөрөөд их явдаг болжээ. Тэх. Тэгээд энийг бас та жаахан анхаараарай гэж хэлэх гэсэн юм.

Ер нь ажиглаад байхад Эдийн засгийн байнгын хороонд 7, 8 сайд орчихсон. Манай Байнгын хороонд чинь бараг Засгийн газрын гишүүн бараг байхгүй байгаа байх. Тэгээд Засгийн газрын гишүүд тэнд бүгдээрээ байгаад байгаа учраас асуудлууд шууд засгийн бодлогоор явна гэж бодоод Эдийн засгийн байнгын хороо руу бүгдийг нь өгөөд байгаа юм уу? Ийм байдал ер нь сүүлийн үед ер нь байнга анзаарагддаг болоод байна. Эдийн засгийн байнгын хороо чинь бүхий л асуудлуудыг хэлэлцдэг боллоо. Тэгээд энэ дээр та жаахан анхаарал хандуулаарай гэж хэлэх гэсэн юм.

**Б.Саранчимэг:** Ганболд гишүүнд баярлалаа. Тэгэхээр одоо бас энэ 5 дахид Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тал дээр бас Засгийн газар өргөн барьчих юм бол энэ 5 дахь өдөр Үндсэн хуулийн төсөл бас хэлэлцэгдэнэ нэмэлт, өөрчлөлт нь.

Ер нь бол энэ Дэгийн тухай хуулиараа бол Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн дундуур хэлэлцэн шийдвэрлэж болно гэсэн байгаа. Тэгэхээр ажлын хэсгийн, ажлын дэд хэсгүүд бас ингээд ороод явчих боломжтой байгаа.

Нөгөө талаар Улсын Их Хурлын дарга яг энэ хэлэлцэх асуудал дээр ингээд бас цохоод явж байгаа. Манайх болохоор Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй гээд ороод ирчихсэн байгаа учраас Байгаль орчны сайд ч гэсэн энэ аялал жуулчлал гэдэг нэрийг бас ер нь оруулах нь зүйтэй гэдэг ер нь саналыг бас ирүүлж байгаа. Тэгэхээр манай Байнгын хороон дээрээ энэ аялал жуулчлалын салбарынхаа нэрийг бас оруулаад ингээд явах бас учиртай юм байна лээ. Тэгэхээр энэ дээрээ Эдийн засгийн байнгын хороон дээр цохогдоод явчихсан байгаа. Дараагийн асуудлууд дээр бас илүү их анхаарч явна. Тэгэхдээ одоо бас хэлэлцэгдэж өргөн баригдсан хуулиудын хүрээнд манай энэ хэлэлцэх асуудлууд явагдаж байгаа. Туваан гишүүн саналаа хэлье.

**Ц.Туваан:** 5 сарын цаглавар дээр бас ялангуяа энэ хөдөө аж ахуйн салбар руугаа нэлээн ажилламаар юмнуудыг оруулах ийм саналтай байна. Тэгээд бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орох юм байна. Тэгэхээр энэ хүрээнд мэдээж ороод ингээд хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явбал орон нутагт энэ Үндсэн хуулийн танилцуулга явах байх. Тэгэхээр энэ хүрээндээ бас манай Байнгын хорооноос санаачлаад нэгэнтээ орон нутагт Улсын Их Хурлын гишүүд очвол яг газар дээр нь энэ малчид, хөдөө

аж ахуйн салбар, тэр дундаа энэ тариаланч, ногоочид гээд энэ салбарынхантайгаа нэлээн тулж уулзаж асуудлыг нь ярихгүй бол энэ Улаанбаатар хотод гишүүдийг хэдэн сэтгүүлч хэдэн төгрөгөөр хүнсээ аваад явж байна гэдгийг ярих биш, хөдөө орон нутагт малчид, хаваржилт ямар байна гэдгийг ярих цаг болчихжээ. Маш хүнд байна.

Энэ жил өвөл айхтар хүйтэн өвөл болсон. Малын ер нь амин сүнсийг нэлээн аваад явчихсан байна. Энэ 4 сар бол нэг ч хоног өөдөлсөнгүй. Салхи, шуурга тасарсангүй. Ингээд маш хүнд хавар болж байна. Малын үхэл нэлээн гарч байна. Тэр бага малын үхэл хорогдол, төлийн хорогдлыг бол бүүр ярих ч юм байхгүй. Малын жилбэ гэж юм ерөөсөө алга байна. Малчид ярьж байна хонь хургалчхаад л тэгээд л цаашаа хараад ерөөсөө тоох ч үгүй яваад өгч байна гэж.

Тэгэхээр иймэрхүү асуудлууд бол нэлээн хүнд байна. Үүний гол шалтгаан бол өөрөө энэ мал өөрөө муу тээврийг авсан. Дээрээс нь энэ ер нь бэлчээрийн доройтол гэдэг юм бол бүр хэдэн жилийн дараа гэдэг ойлголт байхгүй болсон. Одоо Монгол Улсын бэлчээрийн тэдэн хувь талхлагдлаа энэ тэр гэдэг асуудал бол бүр байхгүй болсон. Бид нарын яг нүүрэн дээр энэ бэлчээрийн доройтол, цөлжилтийн асуудал бол бүр тулаад ирчихсэн. Мал таргалахаа больсон. Хавар идэх юм байхгүй. Тэгээд дээрээс нь энэ яг энэ хүйтэн хэцүү хавар болоод ирэхээр энэ малын тэжээлийн үнэ гэдэг юм бол бүүр тамтгаа алдлаа. Өвс боодол нь 35 мянган төгрөг, ногоон тэжээл мөн тэрнээс ч бараг өндөр үнэтэй. Хивэг бүүр 25, 6 мянга болоод ингээд огцом гэнэт өсөөд явчхаж байгаа. Энэ асуудал бол энэ хаврын энэ хаваржилт хүндрэл дээр мал аж ахуй малчдыг бол маш их бухимдуулж байна.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас хэрвээ Үндсэн хууль яваад асуудлаа хэлэлцэгдэхээр хөдөө орон нутагт ажиллавал Байнгын хороо санаачлаад

ялангуяа энэ хөдөөгийн гишүүдээ бүүр яг давхар ийм байдалтай танилцаад ирье гэж хэлээд ер нь цаашидаа энэ дээр нэлээн арга хэмжээ авмаар байна.

Хөдөө бас малчдын ярьж байгаа нэг зүйл бол энэ ноолуурын үнэ бас энэ тогтворгүй, ерөнхийдөө ам долларт харьцуулсан үнэ бол бага унасан байдалтай.

Дээрээс нь энэ арьс ширний хөдөө аж ахуйн гаралтай бид нарын бэлтгэсэн энэ түүхий эдийн үнэ, ханиш гэдэг юм бол ерөөсөө байхгүй болчихлоо. Тэгэхээр бид нар орлогогүй байна. Орлогогүй учраас олон мал зэрэг нядалж байж бага хэмжээний орлого олж энэ бэлчээрийн талхагдалд бид нар бас ийм дан байдлаар юу оруулж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөөд ярьж байна.

Тэгэхээр бид нар энэ харьяа Байнгын хорооныхоо хувиар энэ Дарханы арьс ширний цогцолбор энэ тэрнийхээ юман дээр хэдүүлээ бас анхаараад, шахаад явахгүй бол малчдынхаа бэлдэж өгсөн гол энэ ноос ноолуур, арьс шир гэсэн энэ бүтээгдэхүүнээ тийм үнэ ерөөсөө гэдэг юм байхгүй болчихож.

Зарим газар бол мэдээж энэ газар тариалан яг бүх техникүүдээ бэлдээд эхэлж байна. Тэгээд энэ үе дээр энэ газар тариаланчид, тариалан эрхлэгчид, ялангуяа хүнсний ногоо эрхлэгчид бол маш энэ төрийн дэмжлэг туслалцаа ер нь огт хүрч байгаа ч үгүй. Ер нь бол энийгээ нэлээн нэхсэн байдалтай. Энэ дээр тэр Хүнсний хангамж, аюулгүй байдал 36 дугаар тогтоолын хүрээнд нөгөө зээлүүдийг энд л бид нар 10 банкаар өгнө. 1 их наядын зээл өгнө гээд байгаа болохоос биш хөрсөн дээр тэрийг авч байгаа 1 ч хүн алга. Тэгэхээр яг авах гэхээр банкнууд дээр очоод авах гэхээр нөгөө маш олон зүйлийн шалгууртай юм байна. Бүүр маш их.

Тэгэхээр энэ шалгууруудыг давдаг, ногоо тарьдаг тариаланчид бол яах вэ арай жаахан гайгүй аваад сурчихсан.

Ногоочид, малчид бол алга. Тэгэхээр ийм зүйлүүд дээр хэдүүлээ 5 сарын цаглавар дээрээ юм уу, эс үгүй бол Байнгын хорооны даргаас нэг чиглэл ч юм уу гаргаад энэ 5 дахь өдөр Үндсэн хууль хэлэлцүүлээд ингээд хуваарь нь гараад чуулганы бусад асуудал завсарлаад, хөдөө орон нутагт ажиллахаар бол хэдүүлээ бас энэ зүйл дээр анхаарахгүй бол орон нутагт байдал маш хүнд байна. Энийг бас анхаарч өгөөч гэж ингэж хүсэж байна.

**Б.Саранчимэг:** Туваан гишүүнд баярлалаа. Тэгэхээр тантай бас санал нэг байна. Одоо яг өнөөдрийн энэ нөгөө хаваржилтын бэлтгэлийн талаар мэдээлэл сонсох гэсэн боловч салбарын сайд нь өнөөдөр өөрөө томилолттой гэсэн. Тэгэхээр энэ Үндсэн хууль бид нар хэлэлцэж байх хугацаанд энэ шаардлагатай гэсэн мэдээлэл авах бүрэн боломжтой.

Тийм учраас дараагийн хурал дээрээ бас Идэрбат гишүүний хэлсэнчлэн оторжуулалт, бэлчээртэй холбогдуулаад, энэ хаваржилтын бэлтгэлтэй холбогдуулаад энийг бас яам, тамгын газар руу нь яг бүх мэдээллүүдийг нь бэлтгэх ажлуудыг нь өнөөдрөөс эхлээд хангуулаад тэгээд дараагийн хурал дээрээ оруулъя.

Тэгээд та бас бэлчээр хэллээ. Тэр бэлчээрийн асуудал бол үнэхээр бас тулгамдсан асуудал. Тэгэхээр энэ дээр бас Улсын Их Хурал дээр манай Тогтохсүрэн гишүүн болон бусад гишүүд санаачлаад энэ хуулийн төсөл дээр нэлээн ажиллаад, 5 бүс дээр ингээд бүгдээрээ ажилласан шүү дээ. Манай яг энэ Байнгын хорооныхон бүгдээрээ оролцоод, бүх 5 бүс дээр ажилласан байгаа. Тэгэхээр энэнийхээ бас мэдээллийг оруулаад, энэ дараагийн хурал дээр мэдээллээр хангая гэж бодож байна.

Одоо цаглавраа баталъя гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Ганболд гишүүнийг протоколд дэмжсэнээр оруулаарай. Тэгэхээр цаглавар 66.7 хувь дээр нэмэх нь дахиад 1 гишүүн нэмэгдээд 5 дугаар сарын цаглавар батлагдлаа.

10.42 цаг

**Хоёрдугаар асуудал руугаа оръё. Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах байгаа.**

Төсөл гарсан байгаа. Тэгэхээр төсөлтэй холбогдуулаад та бүхэн өөрсдөө дахиж нэрээ нэмж өгөхөөр бол өгөөрэй. Тэгээд Ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Баттөмөр гишүүн. Гишүүдээр С.Ганбаатар, Х.Ганхуяг гишүүн, Ц.Идэрбат гишүүн, Ц.Цэрэнпунцаг гишүүн байна.

Хоёрт ажлын хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг тухай бүрд татан оролцуулахыг ажлын хэсгийн дарга Баттөмөрт даалгасугай гэж байна.



Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгөөрэй. Ганболд гишүүн асуултаа асууя.

**Г.Ганболд:** Би бас л нөгөө саяынхаа ярьдаг юмыг л ярих гээд байгаа юм. Тэгсэн байна гээд. Хэн тэгсэн юм наад 5-ыг чинь. Манай Байнгын хороогоор орж ирж байгаа юм бол энэ Байнгын хорооных нь гишүүдээр яв л даа. Наадхын чинь 3, 4 нь манай Байнгын хорооны гишүүн биш байна шүү дээ. Яагаад ийм юм хийгээд байгаа юм бэ? Энэ чинь бусад Байнгын хорооныхон чинь гаднын Байнгын хорооныхыг хавьтуулдаггүй л юм байна шүү дээ бараг. Тэгэхээр энэ өөрийнхөө Байнгын хорооноос наад хүмүүсээ ахлуулаад яв. Энэ чиглэлийн бид нар чинь мэргэжлийн Байнгын хороо л гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд би наад дотроос чинь би 3 нь манай Байнгын хорооны биш гишүүн биш байна гэж хараад байх юм. Тийм байна уу, үгүй юу даргаа?

**Б.Саранчимэг:** Би сая бол яг энэ тогтоолын төсөл танилцуулахын өмнө Байнгын хорооны гишүүдээс энэ Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд орох гишүүн байна уу гэж асуусан. Тэгээд гишүүдийн саналыг аваад эндээс Идэрбат гишүүн, Цэрэнпунцаг гишүүн орсон байгаа. Органик бүтээгдэхүүн гэдэг өөрөө маш том бас агуулгыг агуулсан яг шаардлагатай ийм хуулийн төсөл байгаа. Тэгээд өөрсдөөс нь манай гишүүдээс орсон, та өөрөө хүсвэл бас энэ хуулийг ахлаад явах бүрэн боломжтой. Манай Байнгын хорооны ихэнх гишүүн өөрөө энэ хуулийг санаачилсан учраас санаачилсан гишүүд өөрсдөө ажлын хэсэгт орох боломжгүй.

Түрүүний бас Байнгын хороон дээр ажлын хэсгүүд гарахад бусад Байнгын хорооноос өөрсдөө саналаа хэлээд ороод ахлаад явсан бас тохиолдлууд байгаа. Тийм учраас болохгүй гэсэн юм бол байхгүй. Одоо бас манай гишүүдээс өөрсдөө орох гишүүн байна уу гэдгийг би бол асуучихсан байгаа юм. 7 гишүүн энэ Байнгын

хорооноос ороод санаачилчихсан. Тийм учраас тэд нар өөрсдөө ажлын хэсэгт орж болохгүй учраас.

Дахиад өөр ажлын хэсэгт орох гишүүн байна уу? Зарчмын хувьд бол зөв. Гэхдээ энийг чинь асуугаагүй шууд баталж байгаа юм биш. Гишүүдээсээ асуусан нэгт.

Хоёрт манай Байнгын хорооны ихэнх гишүүнд өөрсдөө энэ Органик бүтээгдэхүүний тухай хуулийг өргөн барьчихсан байгаа учраас ажлын хэсэгт орж болохгүй байгаа юм. Баттөмөр гишүүн бол өөрөө зөвшөөрөөд, Ганбаатар гишүүн зөвшөөрсөн, Ганхуяг гишүүн зөвшөөрсөн. Татварын асуудалтай холбоотой, дээрээс нь өөрөө Органик бүтээгдэхүүний тухай хууль байгаа учраас Баттөмөр гишүүнд бид нар бас санал тавьсан, зөвшөөрсөн. Тийм учраас та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төслийг баталъя гэснээр санал хураалтыг явуулъя. Дамдинням гишүүнийг дэмжсэнээр оруулаарай. 75 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Өнөөдөр Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан учраас хурлаа дуусгаж байна.

Өнөөдрийн Байнгын хороонд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ баярлалаа.

10.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

